



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, И-мэйл: letter@mecs.gov.mn
Вэб сайт: meds.gov.mn

2024.02.15 № 21612
танай _____-ны № _____-т

ГТББЗСДТ/20240102001 ДУГААРТАЙ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН
СОНИРХОГЧ ЭТГЭЭДҮҮДЭД

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслөөс зарласан тендер шалгаруулалтын ТББЗСДТ/20240102001 дугаартай, “Сургуулийн Wi-Fi холболт, програм хангамж, зорилтот сургуулиудад дижитал тоног төхөөрөмж худалдан авах, нийлүүлэх (угсралт, суурилуулалт, хүргэлт, тохижилт)” тендер шалгаруулалтын баримт бичгийг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад хариу хүргүүлж байна. Үүнд:


№	Тодруулга	Тодруулгын хариу
1	<p>Асуулт: Тендерийн бичиг баримтын бараа нийлүүлэлтийн хуваарьт Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)-г 2024.04.10-ээс 2024.04.10 гэжээ. Эндээс харвал барааг хүлээн авах эцсийн хугацааг 4 сарын 10 гэж үзвэл тендер шалгаруулалтыг 2 сарын 29 ний дотор хийнэ, гэрээг 3 сарын 11 нд хийнэ гэж эергээр тооцвол барааг нэг сарын дотор нийлүүлэхээр байна. Бидний ажилласан олон жилийн туршлагаар 750 ш компьютерыг үйлдвэрлэгчийн агуулахаас шууд нийлүүлэх боломж байдгүй тул захиалгаар үйлдвэрлүүлнэ. Энэ тохиолдолд 10 –долоо хоногт багтаан сургуулиудад нийлүүлэх боломжтой. Энэ асуудал зөвхөн манай асуудал биш бусад бүх тендер оролцогч нарт тулгарч буй асуудал гэж үзэж байна. Иймээс нийлүүлэлтийн хугацааг эргэн харахыг хүсэж байна.</p>	<p>Бараа худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичгийн “Бараа нийлүүлэлтийн хуваарь”-т Захиалагч бараа хүлээн авах хугацаа 2024.04.10-ээс 2024.04.10, “Гэрээний тусгай нөхцөл” –ийн ГЕН 2.6. Бараа нийлүүлэх хугацаа: Нийлүүлэгч тал барааг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс өмнө гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 2.5-т заасан газарт хүргэлт хийж, угсралт суурилуулалтыг бүрэн гүйцэтгэж холбогдох байгууллагад актаар хүлээлгэн өгсөн байна гэж тус тус заасан. Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулахгүй байхаар шийдвэрлэсэн.</p>
2	<p>Тендерийн баримт бичгээс дараах зүйлсийг тодруулах хүсэлтэй байгаа тул та бүхэн хариу явуулж өгч тусална уу. ТШЗ 20.1-ийн 10 дугаарт “Мөн энэ тендерийн техникийн тодорхойлолтод заасан барааг нийлүүлэх боломжтой тендер оролцогчтой хамтран ажиллахаа илэрхийлсэн тодорхойлолтыг үйлдвэрлэгч эсхүл гадаад нийлүүлэгчээс тендер зарласан өдрөөс хойш авсан тодорхойлолтыг ирүүлсэн байх” гэж шаарджээ. Энэ нь барааг нийлүүлэх</p>	<p>Техникийн тодорхойлолтод заасан барааг нийлүүлэх боломжтой гэдгийг нотлох зорилгоор гадаад нийлүүлэгч эсхүл үйлдвэрлэгчээс тендер зарласан өдрөөс хойш авсан албан бичиг эсхүл түүнтэй дүйцэхүйц бусад төрлийн баримт бичгийг ирүүлсэн байх шаардлагатай.</p>

14249 0649

	<p>боломжтой болохыг нотлох “Нийлүүлэгч эсхүл үйлдвэрлэгчээс авсан албан бичгийг” хэлж байна гэж ойлгож болох уу.</p>	
3	<p>Тендер шалгаруулалтын өгөгдөл хэсгийн 18.1 хэсгээс дараах шаардлагыг тодруулах хүсэлтэй байна.</p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлага шаардлагатай гэсэн ба сүүлийн 2 жил буюу 2022, 2023 он тус бүр 3-аас доошгүй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ ирүүлсэн байх шаардлагатай гэж заасан ба түүний дотор 2022, 2023 онуудын аль нэг жилд ижил төстэй бараа нийлүүлснийг нотлох нэг гэрээ актын хуулбар ирүүлэх гэж давхар заасан байна.</p> <p>Ижил төрлийн бараа нийлүүлсэн туршлагыг нотлоход 2022, 2023 он тус бүр 3 гэрээ илгээх шаардлагатай юу эсвэл 2022, 2023 оны аль нэг жилд нэг гэрээг актын хамт илгээвэл гэрээний туршлагыг нотлох уу. Үүнийг тодруулж байна.</p>	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 18.1 Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардлагатай” гэсэн хэсэгт шаардсан шаардлагын дагуу тендерт оролцогч нь 2022 он, 2023 он тус бүр 3-аас доошгүй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ ирүүлсэн байх шаардлагатай бөгөөд эдгээр гэрээнүүдийн аль нэг нь захиалагчийн батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 80 хувиас багагүй ижил төстэй бараа нийлүүлснийг нотлох гэрээ байна.</p>

Ирүүлсэн тодруулгатай холбоотой тендер шалгаруулалтын баримт бичиг болон тендер хүлээн авах эцсийн хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулаагүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.БАТЦЭЦЭГ